

МОНГОЛ БААТАРЛАГ ТУУЛЬ ДАХЬ АНДГАЙ ТАНГАРАГ ТАВИХ ЁС

С.Дашдэжид

Товч агуулга: Баатарлаг туульд монголчууд бидний түүх соёл, ёс суртахуун, аж амьдрал, хүсэл эрмэлзэл зэргийг өргөн дэлгэр тусгасан байдаг. Монгол ёсонд анд нөхөд бололцох, андгай тангараг тавих тодорхой зан үйлийг ёслон гүйцэтгэж иржээ. Бид энэ өгүүллээрээ халх баатарлаг тууль, ойрад баатарлаг тууль дахь анд сайн нөхөртэй болох, ам тангараг тавих өгүүлэмжийн нийтлэг хэв шинжийг эх хэрэглэгдэхүүн болгон харьцуулан хэн, хэзээ, хэнтэй, хэрхэн андгай тангараг тавьж байгааг тодруулахыг зорилоо. Энэхүү андгай тангараг ёс нь эртний уламжлалаас нэлээд хувирч өөрчлөгдсөн ч язгуур санаа нь хадгалагдаж буй нь монгол аман зохиол, түүхэн эх сурвалжуудын мэдээ баримтаар харагдаж байна. “Гэсэрийн тууж”-д ам тангараг өгч буй өгүүлэмж хатад эмэгтэйчүүдэд холбогдож байгаа нь бусад баатарлаг туулиас өвөрмөц, сонирхолтой юм.

Түлхүүр үг: баатарлаг тууль, андгай, тангараг, зан үйл, илдний ир, цус, бэлэг, хуруу

Монголчууд эртнээс хэлсэн үг, амласан амандаа хүрдэг “За гэвэл ёо-гүй” эрхэм нандин чанартай бөгөөд

Тангараг тонгорогноос хурц

Тонгорог хутганаас хурц

Тангаргаа эвдмэл тамтаг болох

Салаа эвдвэл ёроолд унах

гэхчлэн хэлэлцэж, ам тангараасаа няцаж ухарвал тонгорог хутганд хүрэх бүр цаашилбал үхэл сэхлийн ирмэгт хүрэх хүнд хэцүү үйлтэй байсан учраас аливаад урьтаж дуугарах, мэдэх мэдэхгүй олон үг хэлэлцэх, хэлсэн бол заавал үгэндээ хүрэх, үнэнчээр ханилж нөхөрлөхийг эрхэмлэдэг үгийн үнэ цэнэ, утга учрыг чухалчилдаг ёс суртахуунтай. Энэ эрхэм чанарыг монгол ардын аман зохиол тэр тусмаа баатарлаг туульд маш тодорхой тусгагдсан байна.

“Хорин наймтын тайлбар толь”-д,

Анд: -андгайлж мөргөсөн ах дүү ба ашид итгэмжтэйгээр нөхөрлөгсөд харилцан анд хэмээх ч буй...

Андгай: -цэрэг гаргахын үе андгайлан цээрлүүлж цаазлан зарлах үгийг андгай хэмээмэй. Бас энгийн үе олон жанжин цэргийг цугларуулан дарангуйлан цээрлүүлэх үеийг андгай хэмээмэй (Хорин наймтын тайлбар толь, 1994:18) гэж тайлбарлажээ.

Тангараг: -Өгүүлэн барсан үгс хийгээд үйлдье хэмээсэн явдлаан үнэхээр хөдөлбөргүйгээр таслан тогтохыг тангараг хэмээмэй гээд

Тангараглах: -Ам алдаж андгайлахыг буюу” (Хорин наймтын тайлбар толь, 1994: 1456). Орчин цагийн монгол хэлнээ “андгай-тангараг” гэж хоршин хэлэх болсон.

Андгай тангараг тавих ёс нь өөр өөр овгийн хүмүүс нэг нэгнээ итгэн найдаж, харилцан түшиг тулгар болж, хувь заяагаа нэгтгэх гэсэн зорилгоор зохих ёслол явуулж анд бололцдог заншил юм. “Энд анд бололцогсдын зорилго ямар байсан тодорхой. Өөр өөр овгийн хүмүүс анд болохдоо эмээлийн нэг тохмон дээр өвдөг тулган сөхрөн сууж тангараглана. Аягтай сүүнд хоёр баруун гарынхаа эрхий хурууны өндгийг зүсч хооронд нь нийлүүлэн цусыг нь аягатай сүүнд дусаагаад хувааж ууна. Тийм ёслол үйлдэх үед тэдгээр овгийн ахмад хүмүүс өөд өөдөөсөө эгц харан суух ёстой. Андгай өргөсний дараа харилцан бие биедээ нэн хүндэтгэлтэй зүйлээр бэлэг барьдаг байна” (Батнасан нар, 1979:29). Төрөл садан биш боловч дотно итгэлцсэн хүмүүс хоорондоо ах дүүгийн дотно (ихэвчлэн хоёр эрэгтэй хүн) холбоо тогтоон харилцан барилдах энэхүү ёсны тухай “Монголын нууц товчоо”, “Лу.Алтан товч”, “Судрын чуулган” зэрэг түүхэн сурвалж бичигт олонтой дурдагдсан байдаг. Анд бологсод үнэхээр нэг овгийн гишүүд шиг нэг нэгийгээ дэмжиж байсан ба тэд аж ахуй, эдийн засгийн хувьд хамт нэг амьжиргаатай байснаас “анд хүн амь нэг” гэсэн цэцэн үг гарсан (Гаадамба, 1976:155). Андууд бие биенээсээ андгайдаа үнэнч байхыг шаарддаг бөгөөд андгай тангаргаасаа няцвал өштөн дайсан болдог ба анд бие биений өөдөөс хар ус цацаж андаа тасалдаг байжээ. “Чингис хаан, Жамуха эцэн нар бүс, шагай, морь солилцон 3 удаа анд барилдсан, ам тангарагтай хүрээгүйн улмаас амь насаа өргөсөн” түүхэн сургамжийг хэн хүнгүй мэдэх боловч өөрийн биедээ наашлуулан хэлж, ярихдаа нэгийг бодож, хоёрыг тунгаах, зан суртахууны хэм хэмжээг ухаж байхыг сэрэмж гэлтэй.

Монголчуудын анд бололцох заншилд улаан ногттой цагаан зүсний морь, бүс хоёрыг солилцох нь эрхэмлэж ирсэн уламжлалт зүйл юм. Морины цагаан зүс нь сүүг, улаан ногт нь ураг ураглахыг /яс, цусан төрөл/, бүсээ солилцох нь сүнс сүлд, амь нэгтэй болж байгааг бэлгэддэг. Түүхэн сурвалж бичиг, аман эх хэрэглэгдэхүүнд дээрх зан үйл нь “...цусдаж андлах ёс, амалдаж андлах ёс, шүтээнд андлах ёс, бэлгээр андлах ёс”, тусалж андлах ёс” гэх зэрэг ... (Ганбат, 2006:76)” гэж хэд хэдэн зүйлийн амлалт байна. Мөн ойрад монголчуудын андгай тангараг тавих уламжлалд “нохой зүсэж, цахиур бууны хооронд явж, өөртөө авч явсан ариун ном, бурханд мөргөөд судар эрхи үнсч, хутга долоож, хоолойдоо хүргэх эсвэл хутга сэлмийг нүүр, хүзүү болон толгойдоо тавьж тангараг өргөж байжээ. ...Хутга сэлэм, бууны ам долоох, бурханд мөргөх ёс нь тангаргаа зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагыг илэрхийлж буй юм. Өөрөөр хэлбэл, амласан амлалтандаа хүрэхгүй, түүнийг зөрчвөл амийг нь хөнөөнө гэсэн утгатай (Баярцэцэг, 2016:81) гэж дурдаад энэхүү өвөрмөц зан үйл нь ойрад монголчуудын шүтлэг бишрэлтэй холбоотойгоор хувьсан өөрчлөгдөн ирсэн тухай дүгнэн бичжээ.

Монгол баатарлаг туульст “ах дүү бололцон андгай тангараг тавих”, “өстөн дайснаа өршөөн ам мөчгийг нь авах”, “хэцүү бэрх үйлийн хийж гүйцэтгэхдээ андгай тавих” гэсэн гурван зүйлээр харилцан ам тангараг өргөж, андгайтай үгсээ хэлэлцэн нэгэн биеэ давхар, нимгэн дээлээ зузаан болгож, өстнөө хамтран даралцах эсвэл амласандаа үл хүрвэл амийг нь авах тухай зан үйл тодорхой харагдаж байна.

Ах дүү бололцон андгай тавих:

Хаан Чингил баатар Чин хааны хөвгүүн Цэцэн улаан баатар, тэнгэрийн хааны хөвгүүн Төр зул баатартай анд барилцан ах дүүс бололцъё гээд

Морины дэлээс нэг хялгас

Тасалж авалцаад

Алтайн уулын аман талаас

Ган жадны үзүүр барилцаад

Гарын нэг нэг хуруунаас

Цус гаргаж амсалцаад

*Нэг эхийн үр сад
Нэг эхээс гаралцсан
Ах дүү боллоо гэж...* (Монгол ардын баатарлаг тууль, 1982: 82, 86).

Ханхарангуй эхнэрээ аваад орон нутагтаа харих замд Хиргиссайнбуйдар анд бололцохдоо

*... Орой дээр нь Очирваань
Магнай дээр нь
Махагалын бурханаа тавьж,
Атаа тангаргаа авалцан,
Аминаасаа ах дүү
Гурвуул болон...* (Эрийн сайн Ханхарангуй, 2016:89).

Бум Эрдэнэ Хийгийн хүйтэн хөх зэвтэй уран дархчуудын хийсэн зэр зэвсгээр тэмцэлдэж тэнцээд, аав ээжийн хайрласан эгэм дал, эрхий хоохойны тэнхээгээр авалцаад хүч тэнхээ ижил тул ахан дүүс бололцохдоо

*...Хурууныхаа үзүүрийг
Хурц хутгаар огтолж
Халуун бүлээн цусаа долоож
Амин ах дүү бололцоод
Амраг үгээ
Чихэн дээн хэлэлцээд
Амтат идээгээ
Амаараа авалцаж идээд
Амин ах дүү хоёр бололцоод
Хүдэр цоохор нумынхаа
Хөвч доогуур шургаад
Хүж хар болд
Илдийн ирийг долоолцоод
Цустай дайн
Тостой хуримаас
Тун бүү дуталцъя гэж
Ам тангаргаа өргөөд
Амин ах дүү хоёр болов...* (Бум эрдэнэ, 1985:136).

Заан буйдан баатрын хүч тэнхээ, зориг зүрх ихтэйг Дань хүрэл хараад “үүнийг алаад хүж хар махаар нь хүнс хоол болшгүй, хүрэн улаан цус нь унд болшгүй, харийн хол газарт хань бололтой, хатуу хар дайсанд туг бололтой, харин ганц төрсөн биед хань нөхөд бололтой” гээд

*... Хүдэр хар нумын
Хөвч доогуур шургаад
Хүчит хар болд илдийн
Ирийг долоолцоод
Ам тангараг тавилцаад
Ах дүү бололцов оо...* (Дань хүрэл тууль, 1986:78)

“Үхэж болдоггүй Үүлэн тив, хатаж болдоггүй хатан Хавх баатар” туульд:

... Эрхээ хомхоогийн цусыг долоолгоод

Эвтэй дөрвөн ах дүү болгон цэглэвээ... (Монгол сонгодог туульс, 2016:485)

Баатар эрсийн харихгүй санаа, мохохгүй зориг, харийн дайсанд дарагдашгүй, харавсан суманд даагдашгүй чанарыг эрхэмлэн хожмын их үйлсийн төлөө хүчин зүтгүүлэхийн тулд баатар эрс хоорондын итгэлцэлийн гэрч болгон гарын хуруунаас цус гарган амсалцах, нумын хөвч доогуур шургах, илдний ирийг долоон зэргээр ам тангараг өгөлцөж байна. Эртний тангараг өгөх ёсны уламжлал монгол баатарлаг туульд хадгалагдаж үлдсэн төдийгүй эрхий хурууг эр хүний хүч чадлын бэлгэдэл гэх үзэл, цусаа амсалцсан нэгтгэсэнээр эцэг, эх нэгтэй ахан дүүс бололцох ёсны улбаа хэвээр байна. Хэдийгээр ах дүү болсон ч амлалтаа зөрчвөл хатуу цээрийг болохыг давхар сануулга болгожээ.

Өстөн дайснаа дарж ам тангараг авах:

“Хаан Сийр” туульд:

...Татаж өндийлгөөд

Тангаргий нь аваад

Хариу надад гэм хийхгүй биз?!

-Хийхгүй гэсэн тангаргий нь авч

Сэлэмнийхээ ир долоолгоод... (Монгол ардын баатарлаг тууль, 1982:157)

Өстөн дайснаа дараад дахин дайсгаж, аюул зовлон учруулахгүй байхын хатуу ам тангаргийг авч хэрвээ амласандаа хүрэхгүй, түүнийгээ зөрчвөл амийг нь хөнөөхийн гэрч болгож сэлэм, илд, хутганы ирийг долоолгон оногдуулах хариуцлагыг ойлгуулан ам тангараг авч аюулыг холдуулж байна.

Аливаа үйлийг хийж саадыг давахдаа өөрөө өөртөө ам тангараг тавих:

...Би та хоёрыг эс гүйцвэл

Дөрвөн ган туурайгаа цавчуулж,

Зоо нурууныхаа шөрмөсийг өвчүүлье! гэж

Андгай тавьж хөөтөл

Хоёр галт үнэг

Манан татаад алга болчихжээ...

...Миний андгайг минь

Гүйцэтгэж аль! гэж

Морь нь хэлэхэд

Үхэр сүүл хутгаа

Суга татан авч,

Ган дөрвөн туурайнаас

Аягын чинээ цавчиж

Авч хаяж,

Зоо нурууны шөрмөснөөс

Эрхий хуруу дарам

Газар хагалж...

...Хурдан морины туурай долоож

Хурц хутганы ир долоож

Андгай тангараг аваад... (Халх ардын тууль, 1991:107)

... Хийгийн хүйтэн
Хөх төмөр зэв гэдэг болбол
Эхээс гарахдаа
Эмэгтэй хүнд эндүүрэгдээд
Нэг харвагддаг болбол
Эрхий хомхойгоо
Тайруулж хоцорно гээд
Ам тангараг аваад төрсөн гэлээ... (Бум эрдэнэ, 1985:129)

Эрийн сайн Ханхарангуй Нархалзантуулай бөхтэй барилдаад “эрийн сайн эрийг алахгүй харин анд нөхөд, ах дүү гурвуулаа бол оо!” гэхэд Нархалзантуулай:

...Жаахан эр бярдаа найдаж
Эрийн дор орохгүй.
Орж гэхэд
Эрхий хуруунаасаа өвчин
Амь биеийг ална гэж
Андгай тангаргаа өгсөн юм.
Тэр тангараг минь хэцүү байна гээд
Та над өөрийнхөө
Хурц зэвсгээ өг! (Эрийн сайн Ханхарангуй, 2016:225)

гээд Ханхаранхуй түмэн хүний толгойд төдөлгүй явдаг түүхий улаан илдийг сугалж аваад эрхий хуруунаасаа өвчөөд Нархалзантуулай бөх үхжээ.

Аливаа үйл хэрэг бүтээх, хэцүү бэрхийг туулах, саадыг давахдаа өөрөө өөртөө андгай тангараг тавьж хэрэв зээ амласандаа хүрч чадахгүй бол эр хүний хүч чадлын бэлгэдэл болох эрхий хуруугаа огтлон, өөрөөс илүү эгэмтэнт зайгаа тавьж өгөхөө амалдан андгайлдаг. “МНТ”-ны 254-р зүйлд “Чингис хаан “хөвгүүдийн минь ах Жөчи буй зэ, юу хэмээмүү, чи хэл” гэхэд Жөчийг дуугарахын урьд Цагаадай өгүүлрүүн: “Жөчийг хэл хэмээхдээ Жөчийг юүгий түшиж өгүүлмүй. Энэ мэргэдийн цулхалзуурт бид хэрхэн мэдүүлнэ” хэмээхүйд Жөчи босоод Цагаадайн заамнаас шүүрч өгүүлрүүн: “Хан эцэгт бусдын эс хэлэгдлээ. Чи намайг хэрхэн ялгамуй? Ямар эрдмээр илүү чи! Гагц хэцүүгээрээ магад илүү энэ чи

Онтдож чамд гартваас
Эрхийгээ огтолж огоорсугай
Абалдаж барилдаж чамд ялагдваас
Унасан газраас бүү боссугай
Хан эцгийн зарлин мэдтүгэй

хэмээв. Жөчи, Цагаадай хоёр заамнаасаа барилцаж байн бүхүйд...” (Цэрэнсодном, 2000:168) Жөчийг мэргэдийн цулхалзуур гэж хэлсэнд ихэд уурлан Цагаадайн заамнаас шүүрч

Онтдож чамд гартваас

Эрхийгээ огтолж огоорсугай

хэмээн үргэлжид адлагдан, үгний үзүүрт чичүүлж, нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах мэт удаан хугацаанд гадуурхагдах байсан гомдлыг өөрийн байр суурь, амь насаар дэнчин тавьж нэг мөр болгох ам гарч байна. Хэдийгээр Жөчийн тухай эргэлзээтэй байдаг ч эцэг хаан нь түүнийг хөвгүүдийн ахмад, цэргийн сайн жанжин гэж эрхэмлэн дотночилох байдал Цагаадайн уур хилэнг бадрааж, бусдын өмнө хэлэх ёсгүй нууцыг ил болгосонд “эрхий”-дээ тулахад хүргэжээ. Мөн “Эрхий мэргэн”-ий домог дахь өөрөө эр хүний ам тангаргийн

ёсоороо эрхий хуруугаа огтолж хаяад, эр хүнээ байгаад, хар ус уудаггүй, хагд өвс иддэггүй тарвага болоод харанхуй нүхэнд амьдардаг болсон өгүүлэмж монголын уран зохиол, баатарлаг туульд нийтлэг байна. “Эрхий”-ээрээ ам тангараг тавих ёс нь монголчуудын ан агнуур, цэрэг дайны үйлтэй холбогдох бөгөөд “Эрхий мэргэн” гэж цоллож эр хүний хүч чадлын бэлгэдэл болохын нь хувьд домог үлгэрт “эрт цагт их хүч чадалтай эр байгаад хүчийг нь бууруулахын тулд эрхий хурууг нь огтолж, баавгай болсон юм гэнээ” гэхчилэн ярилцдаг бөгөөд эр хүнээ байж эрэмдэг, зэрэмдэг нэгэн болох эсвэл амьтан (тарвага, баавгай) болж хүч тэнхээтний эрхшээлд орох гэсэн санааг илэрхийлж байна.

Ийнхүү “эрхий хуруу” эр хүний ам тангаргийн гэрч болдог бол “чигчий хуруу” нь эмэгтэйчүүдийн ам алдах өгүүлэмжтэй холбогдож байна. Гэхдээ монгол баатарлаг туулиас хатад, эмэгтэйчүүд ам тангараг тавьж буй өгүүлэмж байсангүй харин “Гэсэрийн тууж”-ид цөөнгүй байгаа нь ихэд сонирхол татлаа.

“Бээжин барын Гэсэр”-т:

“Гэсэр: “Би дийлбэл чамайг авъя” гэв.

Ажу мэргэн: “За” гэв.

Гэсэр: “Энэ үгээ баталж миний чигчийн хурууны цусыг чи долоох буюу?” гэв. Ажу мэргэн: “За” гэв. **Чигчийгээ хатгаж цусыг долоолгов”**.

“Юн Фү Сэ-гийн Гэсэр”-т:

“Мангасын эгч нь нохойчилж оцойн суунам буюу.

- Ай хөвгүүн, сумыг минь сугалж авбаас чи миний гэргий болох буюу хэмээв ээс

- За чиний гэргий больё гэв. Гэсэр сумыг төмрөөс нь бариад сугалж авбаас, эмгэн босон гүйн Гэсэр, Ажу мэргэн хоёрыг залгиж орхив. Гэсэр, Ажу мэргэн хоёр дотроос нь зарлиг болруун:

- Чи бид хоёр эрдэнийг залгиж шингээж үл чадах, үтэр гарга. Эс гаргаваас бид хоёр зүрхийг чинь сугалаад гарнам бид хэмээгээд зүрхийг нь тэмтэрвээс, тэр эм ихэд айгаад бөөлжиж гаргаваас, Гэсэр босон гүйн эмийн оройн үснээс нь аваад есөн алд хар шороо суга татаад толгойг нь огтлон завдахад, Ажу мэргэн гараас нь бариад Гэсэрт айлтгаруун:

- Эй богд минь үүнийг алах ёсон үгүй бөлгөө. Чи эдүгээ үүнийг чи биедээ ав хэмээн зарлиг болсонд, **Гэсэр тэр эмийг чи ам алд гэв. Тэр эм Гэсэрийн илдийг долоон ам алдав”**.

... “Бид язгуураа Гэсэр хаан нь хувилгаан олон гэж сонсож бөлгөө. Бид тэр аль цагт учрахыг хэлэх буй за. Чамаас юу гэж өөр санаа буй гэв. Дагуулаа чингээж хэлсэнд, Найхулай гоо охин нь хэлэв:

- Та минь эцэг эхдээ олон дагуул бүү сонсго гэвэл миний **чигчий хурууны цусыг долоо гээд** хэлэв. Та нарыг мэдэхээс би бас мэдэх буюу. Арван зүгийн хаан гэгч зуун мянга таван хувилгаантай, гучин баатартай. Язгуурын Гэсэрийн гэрт үнээ саах хятад эм нь болоосой, үгүй болбоос унс гаргах хятад эм шивээч нь болоосой би гэж санаж билээ гээд **хурууныхаа цусыг гаргаж май гэж өгөв. Төдий тэр дагуул нь булт сайн сэтгэлтэн тул амталж долоов. Тэр охин амталж долоогоод хариу хэлэв.**

- Өхий чи үнэхээр Гэсэр хаанд гаръя гэвэл **миний хурууны цусыг долоо та гэж өгөв. Найгулай гоо нь сайн сэтгэлт тул аван амталж долоов”**.

Энд эмэгтэйчүүд ам тангараг өгөхдөө эзэн эрхшээгчийнхээ чигчий хурууны цусыг долоож чин үнэнч сэтгэлтэн байх, өстөн дайсан эм мангас илдийг нь долоож хэрвээ үгнээсээ харьж буцвал илдний тань ирэнд амиа өгье хэмээн ам алдаж байна.

“Монгол хэлний их тайлбар толь”-д:

чигчий хуруу: - хүний хөл гарын хамгийн жижиг хуруу,

чигчий хуруун чинээ ~ чигчийн чинээ: - чигчий хуруу шиг хэмжээтэй,

маш бага

чигчий хурууны чилээ гаргахгүй: - маш өчүүхэн, хүч чадал муутай

гэж басамжилсан санаа

Ажу мэргэн, Найхулай гоо нар Гэсэр хааны хатан болохдоо ам алдан чигчий хурууны цусыг нь долоож, хаан танд эн зэрэгцэж хаана нь ч хүрэхгүй учраас хоёргүй сэтгэлээр хичээн зүтгэе гэсэн санаа юм. Бас нэгэн түүхийн баримтаас харвал, Саган сэцэний “Эрдэнийн товч”-д: “... бэйжэ “ураг дор ханха үгүй болом гэлээ” хэмээн **хааны чигчий хурууны цуснаас долоон**, хүний арьс ямар ажгуу, үзье хэмээн Хуухайн арьсны тосыг долоогоод, **хар сэтгэлт хааны цусыг нь долоож**, хатган өгүүлсэн Хуухайн тосыг нь долоож эм хүн бөгөөс эрийнхээ өслийг өсөлбэй би, эдүгээ хэзээ үхвээс хамаагүй буюу намайг үтэрлэн (үтэр алаад) хаан харь хэмэвээс ... (Sayang sečen:1984, 282). Өлзийт хунгоо бэйжийн эмэгтэй хүнээс гарамгүй эр зориг, үнэнч сэтгэл, ариун журам, эр нөхрийнхөө өсөл хясалыг авсан авч өнгөнд шунан дурлах ихэс ноёдод ёс суртахууны сургамж болсоор ирсэн.

Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд, монгол баатарлаг туульд:

Эр хүний хүчин чадлын бэлгэдэл болох “эрхий хуруу”, эм хүний энхрий ялдам зан чанарын бэлгэдэл болох “чигчий хуруу”-ны цусыг долоож амталснаар үнэнч сэтгэлийн илэрхийлэл болдог байжээ.

Амласан амандаа хүрэхийн давхар нотолгоо болгож илд, сэлэм, хутганы ир долоолгон урваж няцсан тохиолдолд оноог ял шийтгэлийг сануулан сургамжилдаг байна.

Аман туульсаас түрүү бичигт тэмдэглэгдсэн “Гэсэрийн тууж”-д эмэгтэйчүүдийн ам алдан, андгай тангараг өгөх өгүүлэмжийг ажиглавал ураг хуримын зан үйлтэй холбогдож эр нөхөртэй үнэнч, шударга журамтай байхыг нотолгоо болгосон бол түүхэн сурвалж бичгүүдэд уламжлагдсан “Өлзийт Хунгоо бэйжийн домог”-т цэвэр ариун, үнэнч шударга ёс суртахуунаа батлах хатуу үйл, өсөл хяслын тайлал болж байна.

Abstract

Mongolians' history, culture, morals, life, and aspirations are widely reflected in the heroic epics. In the Mongolian tradition, certain rituals of making friends and taking oaths have been performed. In this article, we aim to emphasize who, when, with whom, and how to take an oath by comparing the common patterns of making friends and swearing in the Khalkha epic and the Oirat epic. Although the ritual of taking an oath has changed considerably from ancient times, its original meaning is preserved, according to Mongolian folklore, historical sources, and documents. Women's connection to the swearing-in story in the epic of Geser is unique and interesting from other heroic epics.

Номзүй

Батсайхан Г., Цолмон С. Монголчуудын анд, андлах ёсны тухай. Түүхийн судлал. Tom. XIV. fasc 3. 24-342 х.

Баярцэцэг Н. 2016. XVII зууны ойрад монголчуудын тангаргийн зан үйл. Шинжлэх ухааны академийн мэдээ. N.02 (218)., х. 81-85. Улаанбаатар.

Бум эрдэнэ. 1985. Улаанбаатар.

Гаадамба Ш. 1976. Нууц товчооны нууцаас. Улаанбаатар.

Ганбат Н. 2006. Монголчуудын андгай-тангаргийн ёс, түүний улс төрийн харилцаанд гүйцэтгэх үүрэг. Tom XXXVI. Fase 1-16. 76-83 х. Улаанбаатар.

Дань хүрэл тууль. 1986. Улаанбаатар.

Монгол ардын баатарлаг тууль. 1982. Улаанбаатар.

Монгол сонгодог туульс. 2016. Улаанбаатар.

Халх ардын тууль. 1991. Улаанбаатар.

Хорин наймтын тайлбар толь. 1994. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Эрийн сайн Хан харангуй. 2016. Улаанбаатар.